



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 02-сарын 15 өдөр

Дугаар А/61

Мөрөн сум

Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг  
хязгаарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.4, Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны гоц халдварт өвчин зөөвөрлөгдөн дамжин тархах болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор гоц халдварт “Хонины цэцэг”, “Бог малын мялзан”, “Гахайн африкийн мялзан” өвчний тохиолдол бүртгэгдсэн бүс нутгаас мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хязгаарласугай.


2. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тандалт, тархвар зүйн судалгаа хийж, мал, амьтны шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг чангатган, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга (Л.Ариунаа)-д, малчид, мал бүхий иргэд, бизнес эрхлэгч нарт мэдээлэл түгээж, орон нутгийн түвшинд хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга, Мал эмнэлгийн тасгийн дарга нарт тус тус даалгасугай.

3. Мал, амьтны гоц халдварт өвчингүй эрүүл бүс нутгаас мал, амьтныг нэвтрүүлэхдээ эрүүл мэндийн үзлэгт хамруулж, халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх ерөнхий болон тусгай арга хэмжээнд хамрагдсан, мал эмнэлгийн цахим гарал үүслийн гэрчилгээ, лабораторийн шинжилгээний хуудастай тохиолдолд нэвтрүүлэхийг Мал эмнэлгийн газрын дарга (Л.Ариунаа), аймаг, сумдын Мал эмнэлгийн улсын байцаагч нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



6717010195

Захирамж 2024